

ДОРНОДАХИНЫ УРАН ЗОХИОЛ

Хятадын зохиолчдын хорооны хэвлэл «**Яруу найраг**» сэтгүүлийн зөвлөл. Гүй Жоу мужийн «Дээж дарсны үйлдвэр» хамтран шинэ шүлгийн «**дээж дарсны хундага**» гэдэг уралдаан зарлан жил гаруй үргэлжлээд саяхан дүнгээ гаргасныг «**яруу найраг**» сэтгүүлийн 1989 оны хоёрдугаарт нийтэлжээ.

Манай сэтгүүл энэ дугаартаа нэгдүгээр байр эзэлсэн хоёр шүлгийг **Ц. Базаррагчаагийн** орчуулгаар нийтэлж байна.

ЗОУ СУОТУН (БНХАУ-ын Шаньси муж)

Бодлоо өчих цаг айсуй

Шаньси нутгийн шальдархан найрагч би
 Шүлэг анх тэрлүүлэхдээ худал үгээр эхэлсэн
 Хэлнийхээ үгсийн сангийн саараас түүн
 Хэдэн хайрцаг янжуурын үнээр сольж байсан минь үнэн.
 Саяхнаас цаг үргэлж яахаа мэдэхгүй эргэж орхихдоо
 Сэтгэлд минь хур бороо шаагих шиг зовинож ядахдаа
 Хоёр хайрцаг янжуур хоослон байж энэ шүлгээ бичлээ
 Нэг хайрцаг янжуур тэгтэл хоёр өдрийн минь цалин.
 Улс оронд минь юу болоод байгааг мэдэх юмгүй
 Үе үе толгой, хөл, гар минь шархиран өвдөх л юм
 Улаан толгойтой, эмийн жор, цас шиг хийсэн айсуй
 Угаасаа эмийн сан, нээх хаах өдөр гаригтай нь бэрх
 Чинэрч шархиран өвдөх нь мөнөөхөн шархиран өвдсөөр
 Чухам хаахнаа өвдөөд байгаагий нь мэдэхээ байлаа.
 Тушаал хэргэмд тачьяан шунах нь үерийн ус шиг сүртэй
 Тэрэгнийхээ хажууд хөлсөө урсгагчийн тариан түрүүг хаман одном
 Ард олны шүүрс алдах дуу, аадар борооныхтой найрч өгөхгүй байнам
 Ад оршиж чухам юу гээч нь болоод байгааг харъя гэж
 Аз дутахад цөөхөөн хүн толгой өндийлгөж байнам.
 Сургуулийн дотуур байр бариулах албан тамга
 Сүүлийн гурван жил хатираад хатираад бүтсэнгүй
 Суугаа мөлхөх төдий жаал охинд, сууц хуваарилж
 Арван найман жилийн дараахь хуриманд нь бэлтгэж байнам.
 Энэ цаг үеийн тухай эргэлзэж гайхахгүй байхын арга алга
 Энэ чигээрээ идээшиж орхих юм бол сэтгэл ээдэж орхином.
 Уранхай цоорхой даавуунд түмэн нөхөөс тавих шиг
 Улиран одох хоног өдөр сэм сэмхээн талийж байнам.
 Олны зарц нарын «Сагстай шувуу» их зээлээр сэлгүүцнэм
 Олхио эзэн нь тавиад оныхоо ээлжийн тэргийг хүлээнэм.
 Зогсоолын тэмдэг олны нүүрийг ширлэж гүйцлээ байнам
 Зоргоороо хэлье гэвч юу ч ярьж огт болохгүй байнам.
 Унаа унаш хүлээх нь тэсвэр хатуужлын тухай ярианы сэдэв
 Урдах зам, тэв тэгшхэн байтал, гэнэт энхэл донхол болном.
 Өнөөх л хурал, яриурын өмнө болдог өнөөх л хурал
 Өнөө болтол чамайг Марксын диалектикаар дайлж дуусаагүй
 Өнөөх л хурлынхаа дараа эрх биш материалист болж орхино.
 Яриураас зэс тогоо хүртэл дэлгэрч тархсан гүн ухаан
 Яалтгүй шинэтгэл цагийн хурдацын л төлөө юм бол
 Яав чиг Гүй Лин¹-гээс да Лиан-руу нисэх хүрэх болном.
 Ойворгон хөвгүүд охид минь алсын далайг алтадахаар одлоо

Ормондоо үлдэгсэд нь албан шаалтаар цүнхний нэгдэлд ажиллаа.
 Гадны хүн, Шаньси-д саяхан ирж, цахиур төмөр цөлмөөд явлаа
 Ганц хуудас цаасаар хэдэн түмэн юань аван одлоо
 Гай түйтгэрийн билбүүрдэн бялдуучлах явдал газар авч
 Гарцаагүй үмхийрэн, үжирэн доройтох нь бололтой
 Сайтар тунгаан үзвээс, дээрх хэрэг явдал болгоныг
 Сац бас зориг зүрх нь хүрч хянан болгоох эсэхийг мэдэхгүй.
 Сүр жавхлант ажил үйлийн хажуугаар бас
 Садар самуун, ичгүүргүй бялангачлал ээрэгцээд
 Бид иймэрхүү л хорвоод аж төрж, амь зууж явнам
 Бут ниргэхгүй бол, бүтээн босгох минь бэрх бизээ.
 Могой алья гэвэл, эхлээд толгой руу нь дэлс
 Молхи доорд ардынхаа үс гэзгийг бүү зулгаа!
 Тэд чинь бас хоёр гартай төрснөө мартаж болоогүй
 Түмэн зовлон уршиг, удсан газраа додомдохоор одох болном.
 Сууцныхаа дусаал гоождог болгоныг бөглөх бүрийдээ
 Шувуу нуруу нь хазайсан эсэхийг ажиглаж сураарай!
 Суурь нь бөх бат эсэхийг будах болгондоо ажаарай!
 Алив хаалт халх болгон, халтай бүхнийг булшилнам
 Алс тэртээ хад хавцалд гал түймэр гарлаа гэхэд
 Аюул зовлон нь нуурын загасанд тусах төдийхээн,
 Огтлон эсгэсэн шархыг дэлгэж байж анаах билүү
 Орь дуу тавин уйлах минь, өвгөд дээдэс минь ээ
 Оорхойгүй бид чинь хүлцэшгүй, харамсам цагтайгаа туллаа. Рү Гү (Жезянь муж)

Эрь Гуозынх нүүсэн нь

Эрь Гуозын-хыг шинэ сууцнаа нүүх тэр өдөр
 Ээм наран нүүр цоргон цоноож байснаа
 Хилэгнэн уурсан тэнгэр нүргэн нүжигнэж
 Хэсэгхэн үүл тосгоны дээгүүр хуйлран шүршив
 Эхнэрийнх нь инээмсэглэл нүдий нь хаагаад
 Энд тэндгүй цаасан буу² нижигнэн, чихий нь дөжрөөгөөд
 Эрь Гуозы л харин юм анзаарах сөхөөгүй явжээ.
 Сайхан ачаалах үедээ Эрь Гуозы ухаан нь гүйж
 Сохор зоос булан руу унасныг мөлхөн байж авчээ
 Шалан завсар зүү унасныг гэрэл барин түүжээ
 Гэнэт Эрь Гуозы-ийн ой той муудсан байлаа.
 Эмгэн болсон ээжээ ор тас мартсан байлаа
 Гадаа гэртгүй шуугилдан байдаг өнөөх л амьтад
 Галуу, тахиа, туулайгаа авч явахаа мартсан байлаа.
 Шинэ сууц өндөр гэж жигтэйхээн жигтэйхэн
 Орж гарахад нь ээжид хэцүү хэцүү!
 Хуучин сууц, гал тогоотойгоо өрөө болохоор
 Орж гарахад нь ээжид амар аа амар!
 Адуусан амьтанд хайртай гэж хачиан хачин
 Адаглаад тахиан дуугаа сонсохгүй л бол
 Амар тайван нойрсохгүй болно хэмээн
 Эрь Гуозы, ээжийнхээ тухай учирлан ярьжээ.
 Эрь Гуозы-н сөөсгөрхөн охин л харин
 Эмгэн ээжийнхээ алчуур дүүрэн нулимс
 Эвэрч хаталгүй гурав хоносныг анзаарчээ.

1. Гүй Лин гэж Хятадын өмнө нутагт байдаг далайн булангийн үзэмжит уул усны нутаг
2. Цаасан буу гэж ёслол баярын үесд буудаж дуу гаргадаг дариар авалцдаг нэгэн зүйл бүүг хэлдэг ажээ.

Н. АЛТАНШАА (БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орон)

МОНГОЛ ХЭЛ

Алтан гургалдайн уянгалах эгшгээс ч уяхан сонсогддог
 Амраг хонгорын найланхай дуунаас ч тодхон санагддаг
 Зүрх хайлам хөгжмийн аясаас ч яруу сайхан
 Зүс үзэгдэм булгийн уснаас ч цэвэр ариухан
 Олон үеийн түүх шаштирыг тэмдэглэж ирсэн
 Одоо цагийн шинжлэх ухааныг эзэмшүүлж өгсөн
 Хүслийг хангагч чандмань эрдэнэтэй ч зүйрлэмгүй
 Хөмрөгийг бялхаагч шижир алтаар ч сольшгүй
 Эртний өвгөдийн минь үүсгэн гийгүүлсэн төрөлх хэлээ
 Ээж аавын минь эрхэмлэн сургасан монгол үгээ
 Мартаж орхивол үр ач нартаа мануус ялтай
 Мандуулж явбал өвөг дээдэсдээ таануус гавьяатай

1980—6--15

ЗАЛУУ ХҮМҮҮС ГЭДЭГ ЧИНЬ

Залуу хүмүүс гэдэг чинь —
 Өндөр үс өрвийлгөөд
 Өчүүхэн сахал сэрвийлгээд
 Өргөн өмд чирээд
 Өрвөлзөж явахыг хэлдэг биш
 Залуу хүмүүс гэдэг чинь —
 Хот зээл хэсээд
 Хоол гуанз эрээд
 Худал үнэн хэлээд
 Хуудуулж явахыг хэлдэг биш
 Залуу хүмүүс гэдэг чинь —
 Шилбэтэй тамхи гозойлгоод
 Шилтэй архи тонгойлгоод
 Ширээн доогуур тонгорцоглоод
 Шийгээ дуулахыг хэлдэг биш
 Залуу хүмүүс гэдэг чинь —
 Хүүхэд багачуудыг дайраад
 Хөгшин настныг гишиглээд
 Хүүхэн хүнийг дагаад
 Хөндлөн аашлахыг хэлдэг биш

Залуу хүмүүс гэдэг чинь —
 Шамдан чармайн суралцаад
 Шинжлэх ухааныг эзэмшээд
 Шинэ зүйлийг санаачлаад
 Шаламгайлан явахыг хэлдэг юм
 Залуу хүмүүс гэдэг чинь —
 Ууж идэхээ орхиод
 Унтаж хэвтэхээ мартаад
 Уралдаан тэмцээн өрнүүлээд
 Урагшилж явахыг хэлдэг юм
 Залуу хүмүүс гэдэг чинь ---
 Ган зоригоо хөвчлөөд
 Газар дэлхийг өөрчлөөд
 Гавьяа зүтгэл байгуулаад
 Гарамгайлж явахыг хэлдэг юм
 Залуу хүмүүс гэдэг чинь —
 Үхэх амиа цөөлөөд
 Үнэн соёлыг баримтлаад
 Өвгөн настнаа залгамжлаад
 Өөдөлж явахыг хэлдэг юм

Залуу хүмүүс гэдэг чинь —
 Хоёул гурвуул нийлээд
 Хоршоо сүлбээ байгуулаад
 Хуруу хумс хөдөлгөөд
 Хулгайлж явахыг хэлдэг биш
 Залуу хүмүүс гэдэг чинь —
 Цааз хуулийг зөрчөөд
 «Цагаан бугуй»¹ зүүгээд
 Цагдаагийн газар суугаад
 Цагийг нөгцөөхийг хэлдэг биш.

Залуу хүмүүс гэдэг чинь —
 Саад бүхнийг даваад
 Саар бүхнийг тэвчээд
 Сайн бүхнийг сураад
 Сайшаагдаж явахыг хэлдэг юм.

1981—1—13
 Буулгасан **М. Зэнээ**

ТАНЫ МЭДЛЭГТ

БУДАЛИН ОРДОН

О. Оюунгэрэл
Л. Лхамдулам

Дэлхийд алдартай Буддын шашны тэргүүн Далай ламын ордон Будалинг Нарны хот Лхасын Марбори (Улаан уул) уулыг дамнуулан барьжээ. 13 давхар, 110 м өндөр энэхүү ордон зүүнээс баруун тийш 360 м сунаж байрласан нь Лхасын аль ч өнцгөөс бараа сүртэй сүндэрлэн харагдана. Будалин ордны санскрит дуудлага нь «Пудола», энэ нь буддын шашны Жанрайсэг бурхны онгон газар гэсэн үг. Энэхүү эртний барилга нь төвд үндэстний бүтээлч, хөдөлмөрч ард түмний бахархал болсоор иржээ.

Түүхэн сурвалжаас үзэхэд, Будалин ордныг манай эриний 641 онд Төвдийн хаан Соронзонгомбо хаан Тан улсын Тай Зун хааны Вэн Чэн гүнжийг хатнаа болгоход гүнжид зориулж барьсан байна. Марбори ууланд барьсан 999 байшин, мөн уулын орой дээрх олон давхар улаан орд бүхий нийт мянган барилгын цогцос нь Будалин ордны эх суурь болсон ажээ. IX зуунд Төвдийн феодал вангуудын хооронд болсон дайн дажны хөлд Будалин ордон өртөхөд ордны гэсэн зүйлүүдээс Төвдийн хаан Соронзонгомбо, Тан улсын Вэн Чэн гүнж, Балбын вангийн охин Чи Зун гүнжийн шавар баримал, хөргүүд л ойролцоох Фаван агуйгаас хожмоо олдсон байна.

Харин өнөө хүртэл сүндэрлэсээр буй Будалин ордныг XVII зууны эхээр V Далай лам дахин сэргээн бариулсан түүхтэй. V Далай ламыг бүх Төвдийн тэргүүн болоход нь түүний засгийн нэр хүндийг илтгэн харуулах үүднээс 1645 оноос ордныг сэргээх ажил эхэлжээ. 1653 онд шинэ Будалин ордны гол хэсгийг барьж дууссан тул Далай лам Брэвэн хийдээсээ уг ордонд шилжин суужээ.

Энэхүү сүрлэг ордон нь Улаан, Цагаан хоёр барилгаас бүрдэнэ. 4 давхар Цагаан ордныг нь 1659 онд барьж дууссан ба голын 9 давхар Улаан ордныг нь Төвдийн төрийн дээд сайд Санжа-жамцо (1653—1705) 1690—1694 онд V Далай ламын шарилыг байрлуулахаар бариулжээ.

Төвдийн түүх бичлэгт тэмдэглэн үлдээснээс үзэхэд Улаан ордныг сэргээн засварлахад хятад, монгол 50 гаруй алдар цуутай гар

1. Эмэгтэй хүний гоёл